Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын
2023 оны 98 дугаар тушаалын 6
дугаар хавсралт

**ТӨВ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ, МЭРГЭЖИЛТЭН БОЛДЫН АГИЙМААГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

2025 оны 06 дугээр сарын 25-ны өдөр

| № | **Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ** | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин /биелэлт/ | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлт хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 Нэг. “Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах” зорилтын хүрээнд: | | | | | | | |
| *1.1 Нийгмийн даатгалын сан болон үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулах, тайлагнах” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД* | | | | | | | |
| 1.1.1 | Аймгийн хэмжээнд шинээр тогтоогдож буй тэтгэвэр тогтоолт, олголт, тэтгэврийн хувийн хэрэг дэх баримтын бүрдүүлэлт, эрх зүйн үндэслэлийг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгнө. | *Шинээр тогтоогдсон тэтгэврүүд хянагдаж баталгаажсан тоогоор* | | *Хариуцсан 14 сумын бүх төрлийн тэтгэвэр болон Зуунмод сумын өндөр насны тэтгэвэр тогтоолтыг шалгасан байна.* | Тайлант хугацаанд хариуцсан 14 сумдын шинээр тогтоогдож буй 215 иргэний тэтгэврийн тогтоолт, олголт, тэтгэврийн хувийн хэрэг дэх баримтын бүрдүүлэлт, эрх зүйн үндэслэл, мэдээллийн санд бүртгэсэн байдал зэргийг хуулийн хугацаанд тулган шалгаж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулан засуулах арга хэмжээ авч тэтгэврийг тогтоон олгож ажиллаа. Мөн тэтгэврээ өөрчлөн тогтоолгох болон сунгуулах хүсэлт ирүүлсэн 305 тэтгэвэр авагчийн нийт 520 тэтгэвэр авагчийн гаргасан хүсэлтийн дагуу тэтгэврийг хуулийн хугацаанд хянан | 2025.01.01<br>2025.06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | баталгаажууллаа. | | |
| 1.1.2 | Аймгийн хэмжээнд шинээр тогтоогдож буй тэтгэмжийн тогтоолт, олголт, баримтын бүрдүүлэлт, эрх зүйн үндэслэлийг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгнө. | *Шинээр тогтоогдсон тэтгэмжүүд хянагдаж баталгаажсан тоогоор* | | *Шинээр тогтоогдсон тэтгэмжийн тогтоолтыг шалгана* | Жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгохоор мэдээллийн санд бүртгэсэн 154 даатгуулагчийн 769.2 сая төгрөгийн жирэмсний болон амаржсаны тэтгэмж,<br>Ажилгүйдлийн тэтгэмж олгохоор мэдээллийн санд бүртгэсэн 148 даатгуулагчийн 772.7 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж,<br>Мөн нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгохоор мэдээллийн санд бүртгэсэн 90 иргэний 180,0 сая төгрөгийн оршуулгын тэтгэмж,<br>Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгохоор мэдээллийн санд бүртгэсэн 377 даатгуулагчийн 95,6 сая төгрөгийн тэтгэмж нийт 769 даатгуулагчийн 1817,5 сая төгрөгийн тэтгэмжийн тооцооллыг хуулийн хугацаанд хянан шалгаж илэрсэн зөрчлийг тухай бүр арилган тэтгэмжийг олгон ажилласан байна. | 2025.01.01<br>2025.06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.3 | Тэтгэврийн өөрчлөлт, тэтгэвэр авагчдын шилжилт хөдөлгөөнийг тухай бүр бүртгэж, мэдээллийн санд оруулах, мэдээллийн сангийн бүртгэлтэй тулгах, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баяжилтад, тэтгэврийн файл бэлтгэхэд хяналт тавих | Хяналт шалгалт хийсэн тэтгэврийн тоогоор | | Мэдээллийн сангийн бүртгэл хөтлөлт баяжилтад хяналт тавьж зөрчлийг арилгуулсан байна | Тайлант хугацаанд тэтгэврээ өөрчлүүлэх хүсэлт ирүүлсэн 310 тэтгэвэр авагчийн тэтгэврийн өөрчлөлтийг өдөр бүр бүртгэж, хувийн хэрэг материалыг үндэслэн мэдээллийн сангийн бүртгэлтэй тулган хянан шалгаж, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баяжилтад, тэтгэврийн файл бэлтгэхэд хяналт тавьж ажиллаа. Мөн 2024 оны тэтгэврийн тайланг шинэ системээр гаргахтай холбогдуулан давхардсан тоогоор 6814 гаруй тэтгэвэр авагчийн тэтгэврийн олголтыг эксэл тайлантай нэгбүрчлэн тулган шалгаж ажиллаа. | 2025.01.01<br>2025.06.30 | |
| 1.1.4 | Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, үр дүнг тооцож ажиллана | Илэрсэн төлбөр зөрчлийн 80-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | | Өргөдлийн дагуу шалгалтыг явуулсан байна. | Тайлант хугацаанд тэтгэврийн тогтоолт, олголттой холбоотой 1 иргэнээс ирүүлсэн өргөдлийн дагуу мэдээллийн сан болон тэтгэврийн хувийн хэрэг материалыг үндэслэн шалгаж хуулийн хугацаанд албан бичгээр хариу өгч ажиллаа. Мөн дээд газраас ирүүлсэн албан бичгийн дагуу 1 тэтгэвэр авагчийн тэтгэврийн олголтыг шалган 10680,0 төгрөгийн илүү олголтыг илрүүлэн Улсын бүртгэлийн байгууллага болон Цагдаагийн байгууллагад хүсэлт хүргүүлэн холбогдох арга хэмжээ авч төлбөр зөрчлийг 100 хувь барагдуулан ажиллаа. | 2025.01.01<br>2025.06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.5 | Хөдөлмөрийн чадвар алдсаны болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын хугацааны сунгалтад хяналт тавьж, зөрчил дутагдлыг арилгах | Тэтгэвэр авагчдын хугацааны сунгалтад хяналт тавьж зөрчлийг арилгуулсан байна. | | Сунгалт, хяналт хийсэн тэтгэврийн тоогоор | 7 хоног бүр Аймгийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлөөр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгуулсан нийт 204 тэтгэвэр авагчийн актыг мэдээллийн сантай тулган шалгаж сунгалтыг хийж ажиллаа. Мөн тэжээгчийн тэтгэвэр тогтоолгосон боловч гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүний тоо өөрчлөгдсөн, тэтгэвэр авах хугацаа дуусгавар болсон зэрэг 5 иргэний тэтгэврийн дахин тогтоолтод хяналт хийж мэдээллийн санг бүрдүүлэн ажилласан байна. | 2025.01.01<br>2025.06.30 | |
| ***Хоёр.*** “Нийгмийн даатгалын сан болон үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулах, тайлагнах” зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 2.1 Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах | | | | | | | |
| 2.1 | НДЕГ-ын болон Дотоодын хяналт шалгалтаар тогтоогдсон улсын байцаагчийн актын төлбөрийг, хугацаанд нь бүрэн барагдуулна. | Илэрсэн төлбөр зөрчлийг 75-иас доошгүй хувиар барагдуулах | | Актын төлбөр үлдэгдлийн 35% барагдуулсан байна. | Дотоодын хяналт шалгалтаар улсын байцаагчийн актаар тогтоогдсон 10680,0 төгрөгийн төлбөр зөрчлийг хугацаанд нь 100 хувь бүрэн барагдуулж ажиллав. | 2025.01.01<br>2025.06.30 | |
| 2.2 | Нийгмийн даатгалын үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шиийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний | Монгол улсын хууль, УИХ-ын тогтоол, зөвлөмж, ЗГ-ын тогтоол, шийдвэрийн тоо, хэрэгжилтийн хувиар | | Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг 06 сарын 15-ны дотор НДГ-т хүргүүлсэн байна | НДЕГ-ын даргын Монголын үндэсний уламжлалт Цагаан сарын баярын өдрүүдээр амарсан 2025.03.04-ний Мягмар гарагийн ажлыг 2025.03.29-ний Бямба гарагт шилжүүлэх тухай А/71 дүгээр тушаалын дагуу амралтын өдрүүдэд ажил үүргээ гүйцэтгэж ажиллав. НДЕГазраас Монгол улсын харьяатаас гарсан иргэдийн мэдээллийг хүргүүлсний дагуу | 2025.01.01<br>2025.06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлнэ | | | | холбогдох төрийн байгууллагаас мэдээллийг гаргуулан авч тэтгэвэр олголтыг шалган авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг НДЕГазрын хяналт шалгалтын газарт хугацаанд нь хүргүүлэн ажиллаа.<br>Мөн НДЕГазрын даргын “Ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг сайжруулах, ажил эрчимжүүлэх тухай” 01 тоот Албан даалгаврын дагуу биелэлтийг тогтоосон хугацаанд улирал бүр гарган ажиллаа. | | |
| 2.3 | Авилгаас урьдчилан сэргийлэх сургалтад хамрагдаж ХАСХОМ болон мэдэгдэл, тайлбарыг хуулийн хугацаанд нь гаргаж ажиллана. | *Мэдүүлэг, тайлбарыг 1 удаа хуулийн хугацаанд нь гаргах* | | *ХАСХОМ болон мэдэгдэл, тайлбарыг хуулийн хугацаанд нь гаргаж ажилласан байна.* | ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд гарган өгсөн. Авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгээ дээшлүүлэн шинээр ХАСХОМ-г мэдүүлэхэд гарсан өөрчлөлтийн талаарх сургалтанд хамрагдаж, үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллаж байна. Тайлант хугацаанд хуулийн хугацааг баримтлан ХАСХОМ-ийг дахин мэдүүлсэн. | 2025.01.01<br>2025.06.30 | |
| 2.4 | Хариуцсан үйл ажиллагааны хүрээнд бүрдүүлсэн баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэн, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивт хүлээлгэн өгнө, | *Архивт тушаах баримтын тоо, хадгаламжийн нэгжийн тоо, хугацаа* | | *Архивын баримтыг жагсаалтын дагуу архивт дараа оны 1 дүгээр улиралд багтаан хүлээлгэн өгсөн байна* | Хариуцсан үйл ажиллагааны хүрээнд бүрдүүлсэн баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэн, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 1 дүгээр улиралд багтаан архивт хүлээлгэн өгөв . | 2025.01.01<br>2025.06.30 | |
| 2.5 | Ажил олгогч, даатгуулагч, малчин, албан бус | *Зохион байгуулсан Сургалтын* | | *Сургалт зохион байгуулж,* | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулах ажлын хүрээнд аймгийн | 2025.01.01<br>2025.06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөдөлмөр эрхлэгч, тэтгэвэр тогтоолгох иргэдэд судалгаанд тулгуурлан баг, хорооны хэмжээнд нийгмийн даатгалын хууль тогтоомж, шинээр хэрэгжиж буй зохицуулалтуудын талаар сургалт зохион байгуулна. | *тоо, хамрагдсан хүний тоо* | | *иргэд, даатгуулагчдын нийгмийн даатгалын талаарх мэдлэг, мэдээлэл, ззэшилж, хамралт нэмэгдсэн байна.* | Болосврольн газар болон Муйзейн нийт 60 гаруй албан хаагчдад шинээр мөрдөгдөж байгаа хуулийн талаар мэдээлэл өгч тэтгэвэр, тэтгэмжийн талаарх сонирхсон асуултад зөвлөгөө өгч ажиллаа. | | |

ГУРАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1 | ХНХЯам, НДЕГазар болон тус газраас зохион байгуулсан сургалтанд бүрэн хамрагдана | *Сургалтанд хамрагдсан тоогоор* | | *Зохион байгуулсан сургалтанд бүрэн хамрагдана* | НДЕГ-с зохион байгуулсан дараахи сургалтад хамрагдсан байна.<br> Нийгмийн даатгалын ерөнхий газраас 7 хоног бүрийн 5 дахь өдөр явуулж буй 20 удаагийн сургалтад зүүмээр /динамикаар/<br> 2025 оны 01 дүгээр сарын 29-нд Аймгийн прокурорын газраас зохион явуулсан "Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх" талаарх сургалт<br> Авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгээ дээшлүүлэн шинээр ХАСХОМ-г мэдүүлэхэд гарсан өөрчлөлтийн талаарх газрын ЭБАТ-с хийсэн сургалт<br> 2025 оны 01 дүгээр сарын 10-наас 02 дугаар сарын 08-ны өдрийг дуустал хугацаанд" Монгол бичиг"-ийн сургалтад<br> 2025 оны 06 сарын 19-нд Нийгмийн даатгалын ерөнхий газраас явуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүй"-н талаарх сургалт | 2025.01.01<br>2025.06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |
| 3.2 | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/, түүнийг дагаж гарсан дүрэм, журам, тогтоол, шийдвэрийг бүрэн судалж танилцсан байна. | *Мэдлэг чадвар дээшилсэн хувь* | | *Мэдлэг чадвар дээшилсэн байна.* | Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх зөвлөмж, Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улстай “Нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, ОХУ-ын иргэдийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь олгох ажлыг шуурхай зохион байгуулах зөвлөмж, Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хүрээнд аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудаас ирүүлсэн зарим асуулгад холбогдох хууль, журам, дүрэм, зааврыг үндэслэн зөвлөмж, Батлан хамгаалахын сайд, Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн “Заавар батлах тухай” А/95, А/81 дүгээр хамтарсан тушаалаар “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах заавар, НДЕГазрын 2025.01.10-ны өдрийн | 2025.01.01<br>2025.06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 01/73 тоот албан бичгээр хүргүүлсэн "Тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, тэтгэврийн хувийн хэрэг бүрдүүлэх, бүртгэх журам зэрэг дээд газраас гаргасан дүрэм, журам, тогтоол, шийдвэрийг бүрэн судалж танилцан өдөр тутамдаа мөрдөн ажиллаж байна. | | |
| 3.3 | Жендерийн цахим модуль сургалтад бүрэн хамрагдана | Сургалтад хамрагдсан тоогоор | | Зохион байгуулсан сургалтад бүрэн хамрагдана | Жендэрийн үндэсний хорооны "Удирдах албан тушаалтанд зориулсан жендэрийн цахим сургалтад хамрагдан шалгалт өгч Ж-1/2024-3826 тоот сертификат авав.   | 2025.01.01<br>2025.06.30 | |

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ     [signature]     Б.АГИЙМАА

/албан тушаал/     /гарын үсэг/

…